



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2023 оны 06 сарын 02 өдөр

Дугаар A/48

Улаанбаатар хот

Албан томилолтоор ажиллуулах тухай

Засгийн газрын эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1, 8.4 дэх хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны “Албан томилолтоор ажиллуулах журам”-ын 2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Орон нутгийн өмчийн газруудад мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийн удирдамжийг 1 дүгээр хавсралтаар, төсвийн зардлыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Албан томилолтоор ажиллах удирдамжийн биелэлтийг 2023 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн дотор танилцуулахыг Захиргаа удирдлагын хэлтэс (Н.Ганболд)-т даалгасугай.

3. Албан томилолтоор ажиллах албан хаагчдын томилолтын зардлыг зохих журмын дагуу тооцож, дотоод томилолтын зардлаас гаргахыг Ерөнхий нягтлан бодогч (Д.Отгонтуяа)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

132013578

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны ..6.. дугаар сарын .02.-ны өдрийн
А/48 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

АЛБАН ТОМИЛОЛТООР АЖИЛЛАХ УДИРДАМЖ

Зорилго: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, тогтоомж, холбогдох журмыг орон нутагт хэрэгжүүлж буй арга туршлагыг судлах, дэвшилтэт ажиллагааг салбарын хэмжээнд нэвтрүүлэх, Орон нутгийн өмчийн газрын бүсийн уулзалт, зөвлөгөөнд сургалт, мэргэжил аргазүйн зөвлөгөө өгөхөд оршино.

Хаана: Баян-Өлгий, Хөвсгөл, Дундговь аймгуудад.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн, хуваарь:

Д/д	Гүйцэтгэх ажил	Хугацаа	Бүрэлдэхүүн
1	Баян-Өлгий, Хөвсгөл, Дундговь аймгуудад Орон нутгийн өмчийн газрын бүсийн уулзалт, зөвлөгөөнд сургалт, мэргэжил аргазүйн зөвлөгөө өгөх.	2023.06.08 2023.06.10	Ц.Баяр-Эрдэнэ, Д.Дэлгэрмаа, Г.Дэлгэрмаа, Д.Улам-Ундрах, Х.Базаррагчаа
2		2023.06.12 2023.06.14	Н.Ганболд, В.Дарханбаатар, Д.Дариймаа, Г.Туул, Б.Янжинлхам, А.Алтаншагай Х.Базаррагчаа
3		2023.06.28 2023.06.30	Ц.Түвшинзаяа, Х.Базаррагчаа.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 6 дугаар сарын 02-ны өдрийн
1/48 тоот тушаалын 2 дугаар хавсралт

АЛБАН ТОМИЛОЛТЫН ЗАРДЛЫН ТӨСӨВ

(төгрөгөөр)

Д/д	Аймгийн нэр	Нэр	Албан тушаал	Ажил- лах хүний тоо	Ажил- лах хоног	Томилолтын зардал
Баруун бүс- Баян-Өлгий, Ховд, Увс, Завхан, Баянхонгор						
1	Баян-Өлгий	Ц.Баяр-Эрдэнэ, Д.Дэлгэрмаа, Г.Дэлгэрмаа, Д.Улам-Ундрах, Х.Базаррагчаа	ТӨУЗХ-ийн дарга, ХЭЗХ-ийн дарга, бусад мэргэжилтнүүд, жолооч	5	3	1,770,000.00
	Дүн			5	3	1,770,000.00
Төв бүс-Архангай, Булган, Дархан-Уул, Орхон, Төв, Өвөрхангай, Сэлэнгэ, Хөвсгөл						
2	Хөвсгөл	Н.Ганболд, В.Дарханбаатар, Б.Янжинлхам, А.Алтаншагай, Д.Дариймаа, Г.Туул Х.Базаррагчаа	ЗУХ-ийн дарга, Удирдлага, төлөөллийн албаны дарга, бусад мэргэжилтнүүд, жолооч	7	3	2,478,000.00
	Дүн			7	3	2,478,000.00
Зүүн бүс- Говьсүмбэр, Дундговь, Дорноговь, Дорнод, Хэнтий, Сүхбаатар, Өмнөговь						
3	Дундговь	Ц.Түвшинзаяа Х.Базаррагчаа	ТӨХШХ-ийн дарга, жолооч	2	3	708,000.00
	Дүн			2	3	708,000.00
	Нийт дүн			-	-	4,956,000.00